

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН 2025 ОНЫ БАЙГУУЛЛАГЫН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /сая/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хугацаа /I-IV улирал/	Хариуцах нэгж
					Эхний хагас жил	Жилийн эцэс		
Стратеги төлөвлөгөөний зорилго: Дундговь аймгийн хүн амд уламжлалт анагаах ухааны төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг, орчин үеийн анагаах ухаантай хослуулан хүргэх чадварлаг боловсон хүчин бүхий нэгдсэн эмнэлэг болон хөгжинө.								
НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ								
Зорилт 1.1 Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг 96-аас дээш хувьд хүргэж ажиллана.		ГС 24,0	Хэрэгжилтийн дундаж хувь	91,8	93,0	96,0	96,0	
1.1.1	Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Хөдөөгийн сэргэлт-Шинэ Дундговь” хөтөлбөрийн Хүний хөгжлийн сэргэлтийн бодлогод тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэн хэрэгжилтийг тооцож ажиллах.	-	Заалтын хэрэгжилтийн хувь	-	90	91	Зорилт 1: 3.1.1 “Эрүүл Дундговь” хөтөлбөрийн хүрээнд явуулын амбулаторийн үзлэгээр уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг сумдын 160 гаруй ард иргэдэд хүргэн ажилласан. 3.1.6 Байгууллагын 4 эрэгтэй албан хаагчийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Зорилт 2: 3.2.1 Гадаад сургалт: Уламжлалт доторын их эмч П.Цэрэнхандыг нийслэлийн нийт 28 уламжлалт анагаах ухааны их эмч, сэргээн засахын эмч нарын хамт Өвөр Монголын Өөртөө засах орны Хөх хотын Олон улсын Монгол эмнэлэгт 2025 оны 4 сарын 21-ний өдрөөс 04 сарын 25-ны хооронд 5 өдрийн уламжлалт анагаах ухааны мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсан. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын чиглэлээр	

							эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтад уламжлалт анагаах ухааны их эмч П.Цэрэнхандыг хамруулж сургалтын зардалд 360,000 төгрөг, уламжлалт анагаах ухааны бариа заслын заслын сувилагч бэлтгэх сургалтад сувилагч Д.Нандинцэцэгийг хамруулж сургалтын зардалд 243,800 төгрөг нийт 603,800 төгрөгийг зарцуулсан. <u>Дотоод сургалт:</u> АНЭ-ийн яаралтай түргэн тусламжийн их эмч Д.Лувсандагва эмчтэй гэрээ байгуулж, 2 удаа яаралтай тусламжийн суурь болон лавшруулсан тусламжийн сургалт зохион байгуулж нийт давхардсан тоогоор 24 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. 3.2.3 Үндсэн мэргэжлээр суралцаж буй их эмч М.Нэргүйд аймгийн Засаг даргын хүний нөөцийн хөтөлбөрт хамруулж, 5 сая төгрөгийн дэмжлэг олгуулсан.
1.1.2	Байгууллагад хамааралтай хууль тогтоол шийдвэрийг хяналтад авч хэрэгжүүлэн ажиллах.	-	Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хувь	-	90	92	1.Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Засгийн газрын 2024 оны Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 238 дугаар тогтоолын 06, 11 дүгээр хавсралт, Засгийн газрын 2019 оны Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох тухай 5 болон 395 дугаар тогтоолыг тус тус үндэслэн байгууллагын даргын боловсон хүчинтэй холбоотой 13 тушаалыг батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. 2.Төсвийн тухай хууль, Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоол, Эрүүл мэндийн

							сайдын тушаалууд, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалыг тус тус үндэслэн үндсэн үйл ажиллагаатай холбоотой 16 тушаалыг хянуулан, байгууллагын даргаар баталгаажуулсан. 3.Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны “Хариуцлагатай жижүүр ажиллуулах тухай” А/14 дугаартай тушаалын дагуу байгууллагын даргын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн “Хариуцлагатай жижүүр ажиллуулах тухай” А/12 дугаартай тушаалын дагуу албан хаагчдыг хариуцлагатай жижүүрээр ажиллуулсан. 4.Эрүүл мэндийн сайдын 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн “Улаан бурхан өвчний эмнэл зүйн заавар батлах тухай” А/81 дугаартай тушаалын дагуу Ажилчдын дархлааг дэмжих зорилгоор 2025.01.31-ний өдрийн А/03 дугаартай тушаалаар нийт 713,000 төгрөгийн эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл болох дархлаа дэмжих багцыг нийт 18 ажилтанд өгсөн. 5.Эрүүл мэндийн сайдын 2025 оны “Тэмдэглэлт өдөр зохион байгуулах тухай” А/85 дугаартай тушаалын дагуу эмчээ сонсьё, сувилагч, эх баригчаа сонсьё арга хэмжээнд эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан. 6.Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажлын онцлог, ололт амжилтыг байгууллагын фэйж хуудсаар дамжуулан олон нийтэд сурталчилсан. Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хувь /90%/
--	--	--	--	--	--	--	---

1.1.3	Байгууллагын 2024 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажиллах.	-	Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	-	93	94	1.Сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг журмын дагуу боловсруулсан. 2. 2025 оны эхний хагас жилд гадаад, дотоод сургалтад хамрагдсан албан хаагчдын бүртгэл судалгааг гарган бүртгэлжүүлсэн. 3.Өргөдөл гомдлыг бүртгэлжүүлэн, шийдвэрлэлтийг ажлын 8 хоногт багтаан шийдвэрлэсэн. 4.Байгууллагын 20 албан хаагчийн хувийн хэргийг төрийн албан хаагчийн хувийн хэргийг шинэчлэгдсэн журам болон ТА3-ын 600 дугаар тогтоолын дагуу шинээр бүрдүүлж ажилласан. 5. нийт 16 Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчилсэн. Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь /93%/
1.1.4	Эрүүл мэндийн салбарын “Дэмжих жил”-ийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	90	91	“Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих жил”-ийн хүрээнд 2025 оны эхний хагас жилд Эрүүл мэндийн Архины хор хөнөөл-50, Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд-100, Улаан бурхан-644 цахим, осол гэмтлээс сэргийлэх гамшгийн сургалт-16, сүрьеэгээс сэргийлэх-563 цахим, давсны хэрэглээг бууруулах-34, зохистой хооллолт-24, шүд амны хөндийн эрүүл мэнд-12, тамхины хор хөнөөлийн талаар-37 дасгал хөдөлгөөний ач тус- 76 эрэгтэй хамрагдсан. Боловсрол олгох сургалт сурталчилгаанд нийт 38023 хүн хамрагдсанаас эрэгтэй нь 17200 хүн хамрагдсан байна. Байгууллагын 4 эрэгтэйг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. /90/

Зорилт 1.2 Иргэдийн амьдрах, үйлчлүүлэх орчин нөхцлийг сайжруулах, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлнэ.		ГС 5,0	Орчин нөхцөлийг сайжруулсан хувь	90	91	92	100
1.2.2	Эмнэлгийн орны зөөлөн эдлэлийг шинэчлэх.	Г.С 1,0	Гудасны өнгөнүүдийг шинэчлэн сольсон тоо	10	40	-	Үйлчлүүлэгчдийн тав тухтай байдлыг хангах үүднээс хэвтэн эмчлүүлэгчдийн 42 орны гудасны өнгийг 62 метр даавуугаар оёж шинэчилсэн. /62/
1.2.4	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг сайжруулах.	ГС 3,0	Гэрээ байгуулсан эсэх (Тийм 1 , Үгүй 2)	2	1	-	Аймгийн нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер О.Мөнгөнхундагатай 04 дүгээр сарын 01-с эхлэн тоног төхөөрөмжийн үзлэг хийх, засварлах гэрээ байгуулсан. /1/ Искра аппарат, Цахилгаан төөнүүр, СД аппаратуудыг засуулсан. /3/
			Засварласан тоног төхөөрөмжийн тоо	-	2	3	
Зорилт 1.3 Байгууллагын албан хаагчдын баримт бичиг боловсруулах арга зүй сайжруулан дотоодын баримт бичиг болон захирамжлал, зохион байгуулалт, мэдээлэл лавлагааны баримт бичгийн стандарт, шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллана.		-	Баримт бичиг шийдвэрлэлтийн хувь	-	90	100	Байгууллагын албан хаагчдын баримт бичгийн стандартын дагуу албан бичиг боловсруулах арга зүйг сайжруулах зорилгоор албан хаагчдын 1 дүгээр улирлын тайлан, ажлын удирдамж, албан бичиг, тушаалын төсөлд хяналт тавьж, удирдлагад хянуулан баталгаажуулсан. Ц.Бямбасүрэн, П.Цэрэнханд нарын ажлын удирдамжид, үйлчлэгч Э.Болор-Эрдэнэ, туслах сувилагч Ц.Буд, тогооч П.Лхагвасүрэн, эм зүйч Э.Алтанчимэг нарын тайланд, зөвлөх эмч Л.Бямбаагийн эрдэм шинжилгээний хурлын илтгэл зэрэгт баримт бичгийн MNS5140-3 стандартын дагуу хяналт хийн, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. /90/ /80/
			Стандартын хэрэгжилтийн хувь	-	80	81	
			Хяналт хийсэн тоо	-	1	1	

							/1/
1.3.1	Аж ахуй, нэгж байгууллага, ард иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг шуурхай хүлээн авч шийдвэрлэх.	-	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь	100	100	100	2025 оны 06 сарын 09-ны өдрийн байдлаар иргэнээс-6, албан хаагчдаас-18 нийт 24 өргөдөл хүлээн авч бүртгэл үйлдсэн. Өргөдөл гомдлын агуулгын хувьд ажилд орох тухай-6, чөлөө хүссэн-14, хүний нөөцийн чиглэлээр-3, бусад чиглэлээр-1 өргөдөл хүлээн авсан. Шийдвэрлэлтийг ажлын 01-08 хоногт багтаан хуулийн хугацаанд 100 хувь шийдвэрлэсэн. Хүний нөөцийн чиглэлээр ирсэн 2 өргөдөлд байгууллагын даргын 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн Ажлаас чөлөөлөх тухай Б//10, Хүүхэд асрах чөлөө олгох тухай Б/11 дугаартай тушаалаар тус тус шийдвэрлэсэн. /100/ /8/
			Шийдвэрлэлтийн хугацаа	7 хоног	8 хоног	5 хоног	
1.3.2	Захирамжлалын баримт бичиг боловсруулах арга зүйн туршлага судлах, холбогдох эрх бүхий байгууллагын хяналт шалгалтын зөвлөмжийн дагуу арга хэмжээ авч ажиллах.	-	Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	-	85	90,0	Аймгийн эрүүл мэндийн газрын дотоод ажил хариуцсан ажилтан Г.Цэрэннадмидаас байгууллагын даргын боловсон хүчинтэй холбоотой тушаалууд дээр баримт бичиг боловсруулах арга зүйн зөвлөгөө авч ажилласан. Зөвлөмжийн дагуу албан хаагчийг туршилтын хугацаанд ажиллуулах тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.2 дахь хэсгийг, ажлын байр хадгалагдаж байгаа албан хаагчийн оронд ажилтан түр томилж байгаа тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлийг, албан хаагчийн хүүхэд асрах чөлөөтэй байгаа хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр нийгмийн даатгалын зохих санд төлөх заалтыг тус тус оруулан хэрэгжилтийг ханган ажилласан. Нийт хүний нөөцийн

							чиглэлээр 13 тушаал хянагдан, байгууллагын даргаар батлуулсан. Зөвлөмж хэрэгжилтийн хувь /90,0/
1.3.3	Байгууллагын албан хаагчдад албан хэрэг хөтлөлт, дотоодын баримтын бичгийн стандарт, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын талаар сургалт зохион байгуулах.	-	Сургалтын тоо	2	2	3	“Баримт бичгийн бүрдэл, түүнд тавигдах шаардлага”, “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам” сэдвээр сургалт зохион байгуулагдсан. Нийт албан хаагчдын сургалтад хамрагдалтын хувь 83,3% Сургалтын дараах мэдлэгийн түвшинг 12 асуумжтай сонгох асуулгаар шалгасан. Нийт 8 албан хаагч шалгалтад хамрагдсанаас 3 албан хаагч-75%, 2 албан хаагч-83 хувь, 3 албан хаагч 92хувьтай үнэлэгдсэн. Сургалтын үнэлгээний дундаж хувь 83,3%
			Сургалтын дараах мэдлэгийн түвшин	-	75	80-аас дээш	
ХОЁР.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ							
Зорилт 2.1 Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийг нэмэгдүүлэн ажиллана.		ГС 2,4	Чанарын үзүүлэлтийн хувь	95,0	90,0	98,0	80,0
2.1.1	Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний нэр төрлийн тоог нэмэгдүүлэх.	-	Шинээр нэвтрүүлсэн эмчилгээний нэр төрлийн тоо	2	2	4	Чихний чихэвчин төөнө эмчилгээ, 4 шимт ясны шөлөн дэвтээлэг заслыг эмчилгээ үйлчилгээнд шинээр нэвтрүүлсэн. Чихний чихэвчин төөнө эмчилгээнд 5 эмчлүүлэгч, ясны шөлөн дэвтээлэг эмчилгээнд 2 эмчлүүлэгчийг хамруулсны үр дүнд эмчлүүлэгчийн биеийн байдал сайжирсан. /2/
2.1.2	Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн стандарт 5700:2020 Үйлчлүүлэгчийг зөв таних аргыг тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх.	-	Зөв таньж тодруулсан хүний тоо	48	27	55	50 үйлчлүүлэгчийг зөв танин тодруулга хийж эмнэлгийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж, үйлчлүүлэгчийг буруу танин тодруулсанаас үүсэх тохиолдлоос сэргийлж ажилласан. /Унах эрсдэлтэй-18, харшилтай-1, ижил нэртэй-21, харааны бэрхшээлтэй-1 / /50/

2.1.4	Уламжлалт анагаах ухааны эмнэлгийн төлөвлөгөө 2021-2025 он Хануур эмчилгээний тоо, ханах судасны төрлийг нэмэгдүүлэх.	-	Ханасан судасны тоо	65	50	80	2025 оны эхний хагас жилийн байдлаар 50 хүнд хануур засал хийсэн үүнээс 9 төрлийн судас ханадаг байсан, шинээр цөсний шарин судас ханаж 10 төрлийн судас ханаж байна. /50/ /9/
			Ханах судасны төрөл	9	9	11	
2.1.5	/ЭМД-н ахлах байцаагчийн зөвлөмж 2024/ Өвчний түүхийн хасагдлыг бууруулах.	-	Өвчний түүхийн хасагдлын тоо, хувь	20 хувь	10%	20%	2025 оны I-IV сарын байдлаар нийт 77 өвчний түүх түүвэрлэгдсэнээс хасагдсан өвчний түүх байхгүй. /100/
2.1.6	“Хөгжлийн бэрхшээлтэй, эмнэлэгт ирэх боломжгүй иргэд”-д эмнэлгийн тусламж үйлчилгээг гэрээр үзүүлэх.	-	Гэрээр тусламж үзүүлсэн иргэдийн тоо	3	5	10	2025 оны эхний хагас жилд эмнэлэгт ирж эмчилгээ хийлгэж чадахгүй хөгжлийн бэрхшээлтэй 6 иргэнд гэрээр эмчилгээ хийсэн. /6/
2.1.7	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож, уламжлалт анагаах ухааны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх.		Үзлэгт хамрагдсан ХБИ-ийн тоо	-	200	400	06 сарын 01-ний байдлаар Нийт амбулаторийн үзлэг 1789 хийсэн. Үүнээс ХБ-тэй 53 иргэнд үзлэг хийсэн. Нийт 470 үйлчлүүлэгчийг хэвтүүлэн эмчилснээс 39 ХБИ-г хэвтүүлэн эмчилсэн. Хэвтүүлэн эмчилсэн 39 ХБИгэнд осол гэмтлээс сэргийлэх, дохионы хэл, архины хор хөнөөл зэрэг сэдвүүдээр мэдээлэл өгч, сурталчилгаа хийсэн. /92/ /39/
			Сургалтад хамрагдсан ХБИ-ийн тоо	-	30	60	
2.1.8	Магадлан итгэмлэлийн зөвлөмж /2023 оны 10 сарын 22/ Харилцааны бэрхшээлтэй үйлчлүүлэгчээс мэдээлэл авах, мэдээлэл өгөх үйл явцыг тодорхойлж, баталгаажуулах.	-	Сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй үйлчлүүлэгчтэй харилцах журмын хэрэгжилтийн хувь	0	70	80	Лавлагаа мэдээллийн хөтөч ажиллуулах журмыг шинэчлэн баталж, сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй үйлчлүүлэгчтэй харилцах хэсгийг илүү тодорхой болгосон. Журмын хэрэгжилтийг үнэлэхэд 80 хувьтай байсан. Хөтөч сонсгол болон хэл ярианы бэрхшээлтэй үйлчлүүлэгчтэй харилцахад самбар бал, томруулдаг шил зэрэг байхгүй байсан. Хүний нөөц дутагдалтай учир

							хөтөч туслах сувилагчийг сэргээн засах эмчилгээ дээр ажиллуулж байна. /80/
2.1.9	Магадлан итгэмлэлийн зөвлөмж /2023 оны 10 сарын 22/ Арьс салст гэмтээх ажилбарын тандалт хийх.	-	Тандалт хийсэн үйлчлүүлэгчдийн тоо	317	200	350	2025 оны 1-р сараас 6-р сар хүртэл нийт 50 хануур, 75 шивүүр засалд тандалт хийсэн тандалтаар халдварын болон сэжигтэй тохиолдол илрээгүй. /125/ /1/
			Үр дүнгийн судалгаатай болсон байх (Тийм 1 Үгүй 2)	2	0	1	
2.1.10	Эрүүл мэндийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөө 2025 “Эмнэлзүйн тойрон” сургалтад сувилагч нарыг дадлагажуулах.	-	Сургалтад хамрагдсан сувилагч нарын тоо	0	1	2	Эмнэлзүйн тойрон сургалтад хамрагдах шинээр төгсөж ирсэн сувилагч Ө.Цэрэнзул 07 сарын 01-с ажилдаа орох тул хугацаа болоогүй. /0/
2.1.13	Магадлан итгэмлэлийн зөвлөмж /2023 оны 10 сарын 22/ Яаралтай тусламж үзүүлэх багийг байгуулж, дадлага сургуулилт зохион байгуулах.	ГС 0,8	Баг байгуулсан эсэх (Тийм 1, Үгүй 2)	2	1	-	Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн даргын 2025оны 05-р сарын 23-ны өдрийн А/16-р тоот тушаалаар Яаралтай тусламж үзүүлэх багийг тус бүр 6 хүний бүрэлдэхүүнтэй 2 баг томилон багийн ажиллах үүрэг,яаралтай тусламж үзүүлэх журмыг хавсралтаар батлуулсан. АНЭ-ийн яаралтай түргэн тусламжийн их эмч Д.Лувсандагва эмчтэй гэрээ байгуулж 2 удаа яаралтай тусламжийн суурь болон лавшруулсан тусламжийн сургалт зохион байгуулж нийт давхардсан тоогоор 24 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна. /1/ /2/ /80%/
			Удирдамж батлуулж, сургуулилт явуулсан тоо	-	2	3	
			Мэдлэгийн түвшин	-	80,0	85-аас дээш	

2.1.14	Хэрэглэгчийн үнэлгээний эерэг үзүүлэлтийг нэмэгдүүлэх.	-	Хэрэглэгчийн үнэлгээний хувь	90,0	92,0	95,0	Өдрийн эмчилгээнд хамрагдсан 227 үйлчлүүлэгчийн 101 буюу 44.5%-с нь, хэвтэн эмчлүүлэх тасгаар үйлчлүүлсэн 502 үйлчлүүлэгчийн 270 буюу 53,8%-с нь сэтгэл ханамжийн судалгаа авсан. Өдрийн эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчдийн маш сайн, сайн үнэлгээний хувь 98%, хэвтүүлэн эмчлүүлэх тасгаар үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн маш сайн, сайн үнэлгээний хувь 91,1 байна. Дундаж үнэлгээ: 94.5 /94,5%/
Зорилт 2.2 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тавигдах MNS7014:2023 стандартын хэрэгжилтийг ханган ажиллана.		-	Стандартын хэрэгжилтийн хувь	-	80,0	90,0	100
2.2.3	Хэвтэн эмчлүүлэх, өдрийн эмчилгээний өрөө бүрт яаралтай үед эмч сувилагч дуудах дуудлагын хонх байршуулах.	ГС 0,4	Дуудлагын хонхны тоо	7	14	-	10 ширхэг дуудлагын хонхыг 320,000 төгрөгөөр худалдан авсан. Хуучин 7 хонхыг 1 дүгээр давхрын эмчилгээний өрөөнүүдэд байрлуулсан. /17/
2.2.4	Үзлэгийн өрөөний үүдэнд тусламж үйлчилгээ үзүүлэх эмч, сувилагч, үйлчилгээний төрлийн талаарх мэдээлэл байрлуулах.	-	Мэдээлэлийн самбар байршуулсан тоо	0	5	-	12 өрөөний үүдэнд үйлчилгээ үзүүлж буй ажилчдын мэдээллийг дэлгэрэнгүй оруулсан кирилл, монгол бичиг хослуулсан танилцуулга самбарыг шинээр хийж байрлуулсан. /12/
Зорилт 2.3 Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжин ажиллана.		-	Сургалт, сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо /давхацсан тоогоор/	-	1250	1250	Танхимаар 587, өдөрлөгөөр 126, аян 572, цахим мэдээллээр 44832

			Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	1	2	сурталчилгаанд 807 хүн хамрагдсан. Нийт давхардсан 38023 хүн хамрагдсан. Зохион байгуулсан арга хэмжээний тоо Танхимын сургалт 17, өдөрлөг 2, аян 4, цахим мэдээлэл 82, сурталчилгаа 50 /2,092/ /1/
2.3.1	Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр иргэд болон хэвтэн эмчлүүлэгч нарт эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохион байгуулах.	-	Сургалтын тоо	17	14	17	Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр иргэд болон хэвтэн эмчлүүлэгч нарт Танхимын сургалт-17 удаа 587 хүн хамрагдсан, өдөрлөгөөр-126 хүн сурталчилгаанд хамрагдсан, аянд-572 хүн хамрагдсан, цахим мэдээлэлд -44832 хандсан, сурталчилгаа-50 удаагийн сурталчилгаанд 807 хүн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгаанд хамрагдсан байна. Нийт давхардсан тоогоор 38,023 хүн хамрагдсанаас 17,200 нь эрэгтэй байсан. 12 сэдвээр хичээл боловсруулж 707 хүнд гарын авлага зөвлөмж танилцуулсан. /17/ /707/
			Сургалт, сурталчилгаад хамрагдсан иргэдийн тоо /давхацсан тоогоор/	950	920	1415	
2.3.2	Уламжлалт анагаах ухааны эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ард иргэдэд таниулах нээлттэй хаалгын өдөрлөг зохион байгуулах хаалганы өдөрлөг зохион байгуулах.	-	Өдөрлөгт оролцсон иргэдийн тоо	0	50	60	Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг болон Монголын нэгдмэл анагаах ухааны нийгэмлэгтэй хамтран 2025оны 4-р сарын 03-ны өдөр уламжлалт анагаах ухааныг ард иргэдэд сурталчлах нээлттэй хаалганы өдөрлөг болон аймаг сум өрхийн эмнэлэгт ажилладаг уламжлалт анагаах ухааны их эмч, сувилагч бага эмч нарт кредит сургалтын зохион байгууллаа.

			Гарын авлага тараасан иргэдийн тоо	0	100	120	Тэнгэрийн тэмдэг хүүхдийн театрын сургалтын танхимд “МУАУ-ны хувь хүний өвөрмөц чанарыг хэрхэн тодорхойлох вэ, Идээ ундаа, явдал мөрөөр өвчнөөс урьдчилан сэргийлэх арга” сэдвээр Монголын нэгдмэл анагаах ухааны нийгэмлэгийн тэргүүн, Анагаах ухааны доктор профессор, элэг судлаач, хануур заслын мастер багш Г.Машбат, “Уламжлалт анагаах ухааны эмчилгээний мөн чанар” сэдвээр Зөвлөх эмч, клиникийн профессор Л.Бямбаа нар аймгийн ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, уламжлалт анагаах ухааныг сурталчлан таниулах сургалт зохион байгуулж, 126 иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл оролцлоо. /126/ /126/
2.3.3	Эмнэлгийн уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг сурталчлах видео танилцуулга хийх.	-	Видео танилцуулгын хандалтын тоо	0	-	20,000	Эхний хагас жилд хийгээгүй тул 3-р улиралд хийхээр ажиллаж байна. /0/
2.3.4	Нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулж иргэдийн идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэх эрүүл зөв дадал хэвшилд төлөвшүүлэх.	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	1	1	Нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулж иргэдийн идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэх эрүүл зөв дадал хэвшилд төлөвшүүлэх талаар 2025 оны 3-р сараас ажилчид болон хэвтэн эмчлүүлэгч, өдрийн эмчилгээ хийлгэж буй үйлчлүүлэгчдэд ажлын байрны дасгалыг тогтмол хийлгэж хэвшүүлсэн. Мөн 2025 оны 3-р сарын 11-нээс Даваа гариг бүрийн 21:00-23:00 цагт Спорт зааланд байгууллагаараа биеийн тамир чийрэгжүүлэлтийн дасгал хийж байна.
			Хамруулсан хүний тоо	-	1000	1200	
			Хамтран ажилласан төрийн болон төрийн бус байгууллагын тоо	-	3	5	

							Цахимаар ажлын байрны дасгал хийж хэвшүүлэх уриалга гарган ажиллаж 4941 хүнд хүргэсэн. Мөн өглөөний дасгал хөдөлгөөнд байгууллагаараа хамрагдаж байна. БТСГ, ЭМГ, Өрхийн эрүүл мэндийн төв, Сайнцагаан сумын эрүүл мэндийн төвтэй хамтран ажилласан. /4941/ /4/
Зорилт 2.4 “ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТ - ШИНЭ ДУНДГОВЬ” хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллана.		-	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	2	85,0	90,0	100
2.4.2	Хүний нөөцийг дэмжих хөтөлбөр: Анагаахын сургуулиудтай хамтран ажиллаж, төгсөх курсын оюутнуудтай уулзалт зохион байгуулж, хүний нөөцөөр хангалтыг нэмэгдүүлэх.	-	Төгсөж ирсэн оюутны тоо	1	1	-	Этүгэн, АШУҮИС, Шинэ анагаах ухааны сургуулиудтай цахимаар уулзалт зохион байгуулан ажилласан. Этүгэн их сургууль төгсөж байгаа Ө.Цэрэнзул 07 сарын 01-с бариа заслын сувилагчаар ажилд орохоор болсон. Мөн сувилагч Д.Нандинцэцэгийг АШУҮИС-н Монгол анагаах ухааны олон улсын сургуулийн уламжлалт анагаах ухааны сувилагчийн 3 сарын сургалтад хамруулж 7 сарын 01-с бариа заслын сувилагч хийлгэхээр бэлдлээ. /2/ /3/
			Хамтран ажилласан сургуулийн тоо	1	3	-	
2.4.3	Оюунлаг Дундговь хөтөлбөр: “Үндэсний дээл хувцсаа өмсөж хэвших уриалга гаргах тухай” захирамжийг хэрэгжүүлэн монгол бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх.	-	Оролцооны хувь	95	100	100	Үндэсний дээл хувцсаа нийт 6 удаа өмсөж, хэвшүүлсэн. Оролцооны хувь 100% Захирамжлалын хэрэгжилтийн хувь 100% Байгууллагын фэйж хуудсанд 6 удаа мэдээлэн, иргэдийг “Үндэсний дээл хувцсаа өмсөж хэвших уриалга гарган ажилласан. Архивын ерөнхий газрын албан хэрэг хөтлөлтийн сургалтын
			Захирамжийн хэрэгжилтийн хувь	0	100	100	
			Байгууллагын фэйж хуудсад байршуулсан тоо	6	12	16	

			Монгол бичгийн сургалтад хамруулсан албан хаагч нарын хувь	80	85,0	90,0	хөтөлбөрт орсны дагуу монгол бичгийн 23 багц цагийн сургалтад байгууллагын 1 албан хаагчийг хамруулсан.
2.4.4	<u>Цахим-Дундговь дэд хөтөлбөр:</u> Төрийн үйлчилгээг цахимаар хүргэх E-mongolia цахим үйлчилгээний нэгдсэн порталиас эрүүл мэндийн чиглэлээр авч болох мэдээллийг иргэдэд сурталчлах.	-	Сурталчилсан иргэдийн тоо	1000	1000	1200	Төрийн үйлчилгээг цахимаар хүргэх и монголиа сайтаас эрүүл мэндийн чиглэлээр авч болох мэдээллийг нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр цахимаар сурталчилж 100 орчим иргэнд гарын авлага тараасан. Цахимаар 3485 иргэн үзсэн. Мөн и монголиагаас дархлаажуулалтын мэдээллийг хэрхэн шалгах талаар мэдээллийг оруулж мэдээллийг нийт 397 хүн үзсэн. /3882/ /100/
			Гарын авлага боловсруулж тараасан тоо	0	100	150	
ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:							
<u>Зорилт 3.1</u> Байгууллагын мэдээлэл технологи, цахим шилжилтийг эрчимжүүлж ил тод байдлыг ханган ажиллана.		ГС 24,0	Цахим шилжилтийн хувь	60	85,0	90	/100/
			Ил тод байдлын үнэлгээний хувь	60	70,0	80	/34/
3.1.1	Байгууллагын фэйж хуудасны хандалтын тоог нэмэгдүүлэн аймаг орон нутгийн мэдээллийг түгээж, үйл ажиллагааг сурталчлах.	-	Мэдээлэл байршуулсан тоо	191	100	200	2025 оны 06 сарын 09-ны өдрөөр фэйжийн хандалт, оруулсан мэдээллийг тоолоход 157 мэдээ хийж, 109,608 үзэлттэй болсон. Байгууллагын фэйж хуудасны хандалтын тоог нэмэгдүүлж 3000 дагагчтай болгосон. /157/ /3029/
			Дагагчдын тоо	2500	3000	3500	

3.1.2	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.	-	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод байдлын хувь	-	80,0	85	Shilen.gov.mn админ эрхээр хандан байгууллагын 1 дүгээр улирлын байгууллагын үйл ажиллагааг шилэн байдлаар тайланг илгээсэн. 1-р улирлын үнэлгээ 34%-тай үнэлэгдсэн байна. 2-р улирлын мэдээлэл гүйцэт гараагүй тул оруулах ажил явагдаж байна. /34/
			Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод байдлын хувь	-	80,0	85	
			Үзүүлж байгаа үйлчилгээний талаар мэдээллийн ил тод байдлын хувь	-	80,0	85	
3.1.3	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.	-	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хувь	98,0	99	100	2025 оны 06 сарын 10-ны өдрийн байдлаар шилэн дансны хуулийн хэрэгжилт 100 хувь. Нийт 171 мэдээлэхээс, хугацаандаа мэдээлсэн 70 хугацаа хоцорч мэдээлсэн 0 хугацаа болоогүй 101 мэдээлэл байна. /100/
3.1.4	Батлагдсан төсвийн дагуу үйл ажиллагаагаа явуулж 2024 оны санхүүгийн тайланд аудит хийлгэх.	ГС 0,86	Аудитын өөрчлөлтгүй дүгнэлт авсан эсэх /тийм-1, үгүй -2/	1	1	-	2024 оны санхүүгийн тайлангаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан. Аудитын байгууллагаас нийт 7,4 сая төгрөгийн акт, албан шаардлага тавигдсанаас зөрчлийг бүрэн арилгаж биелэлтийг “Санхүүгийн тайлангийн аудитын систем”-д оруулж Аудитын газарт албан бичиг хүргүүлсэн. /1/ /3/
			Аудитын зөрчлийн тоо	0	0	-	
3.1.5	Өмч хамгаалах комиссын үйл ажиллагааг тогтмолжуулан байгууллагын үндсэн хөрөнгөд хяналт тавих.	-	Комиссын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	90,0	99,0	Өмч хамгаалах комисс нь 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгөө батлуулан ОНӨГазарт хүргүүлсэн. Төлөвлөгөөний дагуу эхний хагас жилийн хөрөнгийн тоолллогыг амжилттай зохион байгуулж актлагдах болон 0 үлдэгдэлтэй үндсэн хөрөнгийг ОНӨГазарт хүргүүлсэн.

							/100/
Зорилт 3.2 Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана.		-	Хэрэгжилтийн хувь	95,2	95,0	98,0	94,0
3.2.1	Төрийн албан хаагчийн хувийн хэргийг шинэчлэгдсэн журам болон ТАЗ-ын 600 дугаар тогтоолын дагуу бүрдүүлэх.	-	Албан хаагчийн тоо	18	20	-	Байгууллагын 20 албан хаагчийн хувийн хэргийг төрийн албан хаагчийн хувийн хэргийг шинэчлэгдсэн журам болон ТАЗ-ын 600 дугаар тогтоолын дагуу шинээр бүрдүүлж ажилласан. /20/ /98/
			Бүрдүүлэлтийн хувь	80	98,0	-	
3.2.2	Төрийн алба хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэгжүүлж “Ёс зүйн дэд хороо”-ны үйл ажиллагааг тогтмолжуулах.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	92,0	95,0	Байгууллагын албан хаагчийн ёс зүйг сайжруулах зорилгоор Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг байгууллагын даргын 2025 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн А/03 дугаартай тушаалаар батлуулсан. Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөө нь нийт 20 заалтаас бүрдсэн бөгөөд үүнээс хугацаа болоогүй-4, хэрэгжүүлсэн заалт-14, зохион байгуулсан арга хэмжээний тоо 4, хамрагдсан албан хаагчдын хувь 90%-тай буюу төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь нь эхний хагас жилийн байдлаар 87.5%-тай ажилласан. Ёс зүйн зөрчлийн талаарх гомдолгүй ажилласан. /87.5%/ /4/ /90%/
			Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	4	5	
			Хамрагдсан албан хаагчийн хувь	-	90,0	91,0	
3.2.3	Монгол хэлний тухай хуулийг хангах зорилгоор	-	Хос бичгээр хөтлөж буй албан хаагчийн тоо	1	1	2	Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор хүний нөөц, архив, бичиг хэргийн ажилтан

	байгууллагаас гаргаж буй албан бичгийг хос бичгээр хөтөлж хэвших.		Хос бичгээр гаргасан албан бичгийн тоо	100	110	120	Ц.Ууганбаяр байгууллагын дотоодод үүсэх албан хэрэг хөтлөлтийг хөтөлж байна. 2025 он 06 сарын 10-ны өдрийн байдлаар захирамжлалын баримт бичиг болох байгууллагын даргын А,Б тушаал-36, явуулсан бичиг-29 нийт 65 бичиг баримтыг хос бичгээр хөтөлж хэвшсэн. /1/ /65/
3.2.5	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай тэмдэглэл хөтөлж, мэдэгдэл тайлбар баталгаажуулах.	-	Мэдэгдэл тайлбарын тоо	5	2	4	Эм зүйч Э.Алтанчимэг, нийгмийн эрүүл мэндийн ажилтан Д.Нандинцэцэг нартай хөдөлмөрийн гэрээ байгуулахдаа ашиг сонирхлын зөрчилгүй тэмдэглэл хөтөлж шилэн дансны цахим сайтад оруулсан. /2/
3.2.6	Ажлын байрны сул орон тоог журмын дагуу зарлаж орон тоог бүрдүүлж ажиллах.	-	Боловсон хүчний хангалтын хувь	70	80,0	85	Байгууллагын даргын 2025 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн “Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/02 дугаартай тушаалаар 26 орон тоо батлагдсан. Үүнээс Эм зүйчийн сул ажлын байрыг зарлаж авсан. Боловсон хүчний хангалтын хувь /88,4/
3.2.7	ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд мэдүүлж хэвших.	-	Албан хаагчийн тоо	3	3	-	Дарга, тасгийн эрхлэгч, ерөнхий нягтлан бодогч нар ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд мэдүүлсэн.
3.2.8	Шинээр ажилд орж байгаа албан хаагч нарт “Цахим хөтөч цүнх”-ний багцаар дадлагажуулан сургах.	-	Дадлагажуулсан албан хаагчийн үнэлгээний хувь	70	85,0	90,0	Шинээр ажилд орсон Эм зүйч Э.Алтанчимэг, их эмч Б.Баасансүрэн, П.Цэрэнханд, Б.Болормаа, үйлчлэгч Б.Мягмарсүрэн нарт “Хөтөч цүнх”-ийг танилцуулан байгууллагын танилцуулга 2025 он брошур, уламжлалт анагаах ухааны бүтэц орон тооны схем, бүтэц орон тооны тухай мэдээлэл, байгууллагын эмч, эмнэлгийн ажилчдын танилцуулга зэргийг танилцуулсан. Мөн
			Шинээр ажилд орсон албан хаагчийн тоо	2	2	3	

							хөдөлмөрийн харилцаа талаас Хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам зэргийг ппт бэлдэн танилцуулсан. их эмч Б.Баасансүрэн, П.Цэрэнханд нарын дадлагажуулсан үнэлгээний хувь-85%, дадлагажуулсан их эмч Х.Чирчинсүрэн, тасгийн эрхлэгч Ц.Бямбасүрэн нар уламжлалт анагаах ухааны гардан эмчилгээгээр дадлагажуулсан. Үйлчлэгч Б.Мягмарсүрэнг Халдвар хяналт сэргийлэлтийн багийн гишүүн А.Болор-Эрдэнэ 07 хоног дагалдуулан ажиллуулсан. /85%/ /2/
Зорилт 3.3 Албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулан байгууллагын тохижилтийг нэмэгдүүлнэ.		-	Орчны тохижилтын хувь	80,0	90,0	91,0	100
3.3.3	Хог хаягдал хадгалах цэг байгуулах.	ГС 2,0	Хог хаягдлын цэг байгуулсан эсэх (Тийм 1, Үгүй 2)	-	1	-	Эмнэлгийн баруун талын хашаанд хог хадгалах түр цэгийг шинээр барьсан. /1/
3.3.4	Эмнэлгийн баруун талын хашаанд сүүдрэвч хийх.	ГС 1,0	Сүүдрэвч хийсэн эсэх (Тийм 1, Үгүй 2)	-	1	-	Эмнэлгийн гадна талд үйлчлүүлэгчдийг нарнаас халхлах зориулалттай сүүдрэвч хийсэн. /1/
3.3.5	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх /Эмнэлгийн баруун талын хашаанд ногоон байгууламж хийх/	ГС 2,0	Ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн эсэх (Тийм 1, Үгүй 2)	1	1	-	2025 оны 6-р сард ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор эмнэлгийн урд 9 ширхэг Бүйлс мод суулгасан. /1/ /9/ /90%
			Тарьсан модны тоо	-	6	-	
			Ургалтын хувь	-	90,0	-	
3.3.6	Хог ангилан ялгаж, ялгасан хог хаягдал тушаах.	-	Тушаасан хог хаягдлын хэмжээ	57кг	30кг	40кг	2025 оны хагас жилийн байдлаар Аюултай хог хаягдал 11кг Хурц үзүүртэй хог хаягдал 11.4кг нийт 22,4кг аюултай

							хог хаягдал АНЭ-т өгч устгуулсан бол Хуванцар 10,65кг шил 9,7кг нийт 20,3кг дахин боловсруулах хог хаягдал ангилж ялган тушаасан байна. /42,7кг/
--	--	--	--	--	--	--	--

---oOo---

Нийт арга хэмжээний тоо: 45
 Биелсэн арга хэмжээний тоо: 43
 Биелээгүй арга хэмжээний тоо: 2
 Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт: 95,56%

2025.06.25